



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2022 оны 08 сарын 02 өдөр

Дугаар 16

Мандалговь

**Т.Эрдэнэзаяг Луус сумын Засаг даргын
Тамгын газрын Байгаль орчны асуудал хариуцсан
мэргэжилтний албан тушаалд
нэр дэвшүүлэх тухай**


Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2021 оны 7 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Луус сумын Засаг даргын Тамгын газрын Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Түмэнжаргалын Эрдэнэзаяа 36.0 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.

Хоёр Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа Т.Эрдэнэзаяагийн холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг салбар зөвлөлийн ажлын албанд даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ТӨРБАТ





**Луус сумын Засаг даргын Тамгын газрын Байгаль орчны
асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд
нэр дэвшүүлсэн Т.Эрдэнэзаяагийн тухай дүгнэлт**

1. Т.Эрдэнэзаяа нь 1991 онд Дундговь аймгийн Сайнцагаан суманд төрсөн. 31 настай, эмэгтэй
2. Боловсрол: 2009-2013 онд Хөдөө аж ахуйн их сургуулийг экологи, байгаль хамгаалал мэргэжлээр бакалаврын зэрэгтэй суралцаж төгссөн.
3. Туршлага: 2004-2005 онд Их газрын чулууны уулын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаанд байгаль хамгаалагч, байгалийн нөөцийн хамгаалалт, судалгаа шинжилгээ, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн, 2019-2021 онд Эрдэнэдалай сумын Засаг даргын Тамгын газарт байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн, санал өргөдөл гомдол, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн, 2021 оноос Луус сумын Засаг даргын Тамгын газарт Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байна.
4. Т.Эрдэнэзаяагийн тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан Луус сумын Засаг даргын Тамгын газрын Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ